



ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Г Журам, жагсаалт, төлбөрийн хэмжээг Г
шинэчлэн батлах тухай

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9, 11 дүгээр зүйлийн 11.2, 14 дүгээр зүйлийн 14.8.6, 14.9.8, 14.9.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээний багцад эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн дээд хязгаар”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх оношилгоо, шинжилгээний жагсаалт, төлбөрийн дээд хязгаар”-ыг гуравдугаар хавсралтаар, “Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх өдрийн эмчилгээний оношийн хамааралтай бүлэг, өртгийн жин”-г дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар (Г.Баясгалан)-т ДААЛГАХ нь:

2.1. Даатгалын гэрээ бүхий өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн 2019 оны төсвийн сарын хуваарьт өөрчлөлт оруулах замаар даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний зардлыг батлагдсан төсөвт багтаан гүйцэтгэлээр тооцон санхүүжүүлэх;

2.2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх багцын тусламж, үйлчилгээг иргэд, даатгуулагчид сурталчлах, мэдээлэл хүргэх ажлыг холбогдох газруудтай хамтран шуурхай зохион байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

2.3. Эрүүл мэндийн даатгалын цахим програм хангамжид нэмэлт өөрчлөлт оруулах;

3. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргад ДААЛГАХ нь:

3.1. Холбогдох дүрэм, журам, стандарт, тусламж, үйлчилгээний жагсаалтыг шинэчлэх;

3.2. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнийг стандартад заасан орон тоогоор ажиллуулах, дахин сургах, мэргэшүүлэх чиглэлээр бодлогын хувьд дэмжлэг үзүүлэх;

3.3. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт шинжилгээ хийх, мэргэжлийн удирдлагаар ханган зохион байгуулалтын арга хэмжээг авч, ажиллах талаар Эрүүл мэндийн газарт үүрэг, чиглэл өгөх;

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 08 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн дэд дарга /Д.Дэмбэрэл/-д даалгасугай.

ДАРГА

Д.САРАНГЭРЭЛ

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 23 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ НЬ ХАРИУЦАХ ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс /цаашид эрүүл мэндийн төв гэх/ даатгуулагчид үзүүлэх зарим сэргээн засах үйлчилгээ, гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ, өдрийн эмчилгээ, оношилгоо, шинжилгээ /цаашид тусламж, үйлчилгээ гэх/-ний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Журмыг даатгуулагч, эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эрүүл мэндийн төв дагаж мөрдөнө.

1.3. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт”, “Сум тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт”-ын эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах тусламж, үйлчилгээ энэ журамд хамаарна.

1.4. Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээнд бүх нийтийг хамруулан, хэнийг ч орхигдуулахгүй байх үндсэн зарчмыг баримтлана.

Хоёр. Эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах тусламж, үйлчилгээний багц, зардлын хэмжээ

2.1. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9-д заасны дагуу эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээ нь дараах багцтай /цаашид багц тусламж, үйлчилгээ гэх/ байна. Үүнд:

- 2.1.1. Нэгдүгээр багц: зарим сэргээн засах үйлчилгээ
- 2.1.2. Хоёрдугаар багц: гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ
- 2.1.3. Гуравдугаар багц: өдрийн эмчилгээ
- 2.1.4. Дөрөвдүгээр багц: оношилгоо, шинжилгээ

2.2. Энэхүү журмын 2.1.1-2.1.3-т заасан тусламж, үйлчилгээний 5-аас доошгүй тохиолдлыг нэг багц гэж үзэх ба шаардлагатай тохиолдолд өвчний оношоос хамааруулан нэг даатгуулагчид 10 ба түүнээс дээш хоногоор үргэлжлүүлж болно.

2.3. Даатгуулагчид журмын 2.1.1-2.1.4-т заасан багц тусламж, үйлчилгээг үзүүлэх бүртээ тухайн өдрийн эхэлсэн болон дууссан цагийг эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдсон хурууны хээ уншигч төхөөрөмжөөр бүртгэнэ.

2.4. Журмын 2.1.1, 2.1.2-т заасан багцад хамаарах хоёр буюу түүнээс дээш төрлийн тусламж, үйлчилгээг эмчийн заалтаар эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн дээд хязгаарыг баримтлан үзүүлнэ.

2.5. Сум, тосгоны эрүүл мэндийн төв нь журмын 2.1.2-т заасан багц тусламж, үйлчилгээг хүн амын эрүүл мэндийн 4-5 дугаар бүлгийн даатгуулагчид үзүүлнэ.

2.5.1. Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг өрхийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төвөөс 20 км дотор радиуст оршин суудаг даатгуулагчид үзүүлсэн тохиолдолд уг тогтоолын 2 дугаар хавсралтын 3.1-т заасан төлбөрийн хэмжээгээр нэхэмжилнэ.

2.5.2. Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээг сумын эрүүл мэндийн төвөөс 20 км-ээс дээш радиуст оршин суудаг даатгуулагчид үзүүлсэн тохиолдолд тогтоолын 2 дугаар хавсралтын 3.2-т заасан төлбөрийн хэмжээгээр нэхэмжилнэ.

2.6. Журмын 2.1.3-т заасан багц тусламж, үйлчилгээг "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх өдрийн эмчилгээний оношийн хамааралтай бүлэг, өртгийн жин"-г үндэслэн эмчийн заалтаар улиралд нэг удаа үзүүлнэ.

2.7. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан өрх, сум тосгоны эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад ороогүй тусламж, үйлчилгээг нэмэлтээр үзүүлэхээр бол шаардлагатай мэдээлэл, хүсэлтийг эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлж, шийдвэрлүүлнэ.

2.8. Журмын 2.1.4-т заасан багц тусламж, үйлчилгээг эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх оношилгоо, шинжилгээний жагсаалтын дагуу эмчийн заалтаар өвчний онош тогтоолгох болон өвчний явцыг хянах зорилгоор үзүүлнэ.

2.9. Тухайн сард нэг даатгуулагчид хийгдсэн оношилгоо, шинжилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг хариуцах өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх оношилгоо, шинжилгээний жагсаалт, төлбөрийн дээд хязгаараас хэтрүүлэхгүйгээр нэхэмжилнэ.

2.10. Тухайн сардаа нэг даатгуулагчид үзүүлэх журмын 2.1.4-т заасан багц тусламж, үйлчилгээний зардал эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцах төлбөрийн дээд хязгаараас хэтэрсэн тохиолдолд тухайн улиралд зайлшгүй шаардлагаар улирлын төлбөрийн хэмжээг баримтлан гүйцэтгэлээр нэг удаа

тооцон олгож болно. Улирлын төлбөрийн хэмжээнээс илүү гарсан тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас хариуцахгүй.

2.11. Эрүүл мэндийн төвөөс үзүүлэх багц тусламж, үйлчилгээг эмчилгээ, оношилгооны стандарт, удирдамж, журам, зааврын дагуу нэмэлт төлбөргүй үзүүлнэ.

2.12. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан эрүүл мэндийн төвд үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалтад орсон боловч, тодорхой өртөг зардал шаардахгүй эмч, эмнэлгийн мэргэжилтний зайлшгүй үзэх шаардлагатай эмчийн үзлэг, гардан үйлдэл (амин үзүүлэлтүүд, биеийн бүрдмэл үзлэг)-ийг эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжлэхгүй.

Гурав. Даатгуулагчийн эрх, үүрэг

3.1. Даатгуулагч нь дараах эрхтэй байна.

3.1.1. Өрхийн эрүүл мэндийн төв болон өөрт ойр байгаа сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс чанартай, аюулгүй, тэгш, хүртээмжтэй багц тусламж, үйлчилгээг авах;

3.1.2. Эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний болон эрүүл мэндийн даатгалын талаар холбогдох байгууллагуудаас мэдээлэл авах;

3.1.3. Холбогдох хууль, журам, стандарт зөрчсөн, чанаргүй тусламж, үйлчилгээ үзүүлсэн, эрүүл мэндийн төвийн талаар эрүүл мэндийн даатгалын байгууллага болон холбогдох хяналтын байгууллагад гомдол гаргах;

3.2. Даатгуулагч нь дараах үүрэгтэй байна.

3.2.1. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг хуулиар тогтоосон хугацаанд төлөх;

3.2.2. Эрүүл мэндийн төвөөс багц тусламж, үйлчилгээ авах бүртээ өөрийн хурууны хээг уншигч төхөөрөмжөөр уншуулах, хэрвээ хурууны хээг уншуулах боломжгүй тохиолдолд асран хамгаалагчийн хурууны хээг уншуулах;

3.2.3. Даатгалын байгууллага, эрүүл мэндийн төв, эрх бүхий этгээдийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх, шаардлагагүй тусламж, үйлчилгээг давхардуулан авахгүй байх;

3.2.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахдаа иргэний үнэмлэх, амбулаторын үзлэгийн карттай байх, холбогдох байгууллагаар хүндэтгэлтэй үйлчлүүлэх;

Дөрөв. Эрүүл мэндийн төвийн эрх, үүрэг

4.1. Эрүүл мэндийн төв нь дараах эрхтэй байна.

4.1.1. Даатгуулагчдад үзүүлсэн багц тусламж үйлчилгээний зардлын төлбөрийг батлагдсан төсвийн хүрээнд эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжлэх;

4.1.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын ажилтнуудын ёс зүй, харьцаа хандлага, ашиг сонирхлын зөрчлийн талаар гомдол гаргах;

4.1.3. Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон даатгуулагчид хууль ёсны шаардлага тавих;

4.1.4. Эрүүл мэндийн төв нь даатгалын байгууллагатай харилцан мэдээлэл солилцох;

4.2. Эрүүл мэндийн төв нь дараах үүрэгтэй байна.

4.2.1. Эрүүл мэндийн төв нь бүтэц, үйл ажиллагааны стандарт, өвчин эмгэгийн оношилгоо эмчилгээний удирдамжийг баримтлан даатгуулагчид энэхүү журмын 2.1-т заасан багц тусламж үйлчилгээг аюулгүй, тэгш, хүртээмжтэй, тасралтгүй цогц байдлаар үзүүлэх;

4.2.2. Даатгуулагчид багц тусламж, үйлчилгээг үзүүлэхдээ тусламж, үйлчилгээ эхэлсэн болон дууссан хугацааг хурууны хээ уншигч төхөөрөмжөөр бүртгэх, даатгуулагчийн холбогдох мэдээлэл болон анхан шатны бүртгэлийг цахим хэлбэрээр үнэн зөв, бүрэн хөтлөх, хадгалах, илгээх, НӨАТУС бүхий баримтыг олгох, зайлшгүй шаардлагаар цаасан хэлбэрээр хөтөлж болно;

4.2.3. Эрүүл мэндийн даатгалын цахим системд холбогдож, мэдээллийн технологийн бэлэн байдлыг хангах; *

4.2.4. Эрүүл мэндийн төвийн хаяг, байршил, талбайн хэмжээ, хүний нөөц, тоног төхөөрөмж, үзүүлж буй тусламж, үйлчилгээ, оношилгоо шинжилгээний төлбөрийн хэмжээг үнэн зөв мэдүүлэх буюу өөрчлөлт орсон тохиолдол бүрт албан бичгээр ажлын 7 хоногийн дотор эрүүл мэндийн даатгалын байгууллагад мэдэгдэх;

4.2.5. Даатгуулагчдад эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчлах, мэдээллээр хангах;

4.2.6. Даатгуулагчийн онош, нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд тохироогүй буюу шаардлагагүй тусламж үйлчилгээг давхардуулан үзүүлэхгүй байх;

4.2.7. Ашиг, орлогоо нэмэгдүүлэх зорилгоор даатгуулагчтай үгсэн хуйвалдах, буруу, ташаа мэдээлэл өгөх, тулган шаардахгүй байх;

4.2.8. Холбогдох баримт бичиг, бүртгэл, тайланг үнэн зөв мэдээлэх, эмчлэх, сувилах зөвшөөрөлгүй этгээдийг үйл ажиллагаандаа татан оролцуулахгүй байх;

4.2.9. Эрүүл мэндийн даатгалын байгууллага болон бусад холбогдох байгууллага, эрх бүхий этгээдийн тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

4.2.10. Холбогдох эрх зүйн баримт бичигт дурдсанаас бусад төр хариуцах тусламж үйлчилгээг нэхэмжлэхгүй байх;

Тав. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын эрх, үүрэг

5.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах эрхтэй байна.

5.1.1. Эрүүл мэндийн төвийг Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн баталсан журмын дагуу сонгон шалгаруулах, сонгон шалгаруулалтад тэнцсэн эрүүл мэндийн төвтэй даатгалын гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

5.1.2. Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа, даатгуулагчдад үзүүлсэн тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, зардлын төлбөрт цахим болон цаасан хэлбэрээр хяналт тавих, дүгнэлт гаргах, зөвлөмж, заавар өгөх;

5.1.3. Эрүүл мэндийн төвийн буруутай үйл ажиллагааны улмаас даатгуулагчийн эрүүл мэнд болон даатгалын санд хохирол учруулсан нь тогтоогдвол тухайн эрүүл мэндийн төвд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэх, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

5.1.4. Эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний жагсаалт болон зардлын хэмжээг судлах, үнэлэх, үр дүнг тооцох, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан холбогдох эрх бүхий байгууллагад уламжлах, шийдвэрлүүлэх;

5.1.5. Эрүүл мэндийн төв болон даатгуулагчид хууль ёсны шаардлага тавих.

5.2. Эрүүл мэндийн даатгалын байгууллага нь дараах үүрэгтэй байна.

5.2.1. Эрүүл мэндийн даатгалын байгууллага, эрүүл мэндийн төвийн хооронд мэдээллийн технологийн бэлэн байдлыг хангаж, цахим системд нэвтрэх эрх олгох, даатгуулагчид цахимаар мэдээлэл авах нөхцлийг бүрдүүлэх;

5.2.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж, үйлчилгээний зардлын тайланд дүн шинжилгээ хийх, судалгааны дүнг үндэслэн шаардагдах төсвийн хэмжээг тооцох, даатгалын сангийн зарлагын төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэх;

5.2.3. Эрүүл мэндийн төв болон даатгуулагчаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, хуулийн дагуу шуурхай шийдвэрлэх, даатгалын харилцаанд оролцогч талуудыг мэдээллээр хангах

5.2.4. Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг сурталчилах, мэдээлэл хүргэх үйл ажиллагааг эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулах.


Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд буруутай байгууллага, албан тушаалтан, даатгуулагч холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.2. Журамд тусгагдаагүй бусад асуудлыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн даатгалын гэрээгээр зохицуулна.



Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 23 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ҮЗҮҮЛЭХ ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ТӨЛӨХ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ

№	Тусламж, үйлчилгээний багц	Эрүүл мэндийн даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээ /төгрөг/	
1	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	45 000	
2	Өдрийн эмчилгээ	70 000	
3	Гэрээр үзүүлэх тусламж, үйлчилгээ	3.1. Өрхийн ЭМТ, сумын ЭМТ-өөс 20 км дотор радиуст	50 000
		3.2. Сумын ЭМТ-өөс 20 км-ээс дээш радиуст	70 000
4	Оношилгоо, шинжилгээ	20 000	

---oOo---

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 25 -ны өдрийн 26 дугаар тогтоолын гуравдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ ХАРИУЦАХ ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВӨӨС ҮЗҮҮЛЭХ ОНОШИЛГОО, ШИНЖИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ, ТӨЛБӨРИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Шинжилгээний хэлбэр	Шинжилгээний нэр	Сум, тосгоны эрүүл мэндийн төв	Өрхийн эрүүл мэндийн төв	Төлбөрийн дээд хязгаар
1.	Шээсний шинжилгээ				
1.1.	Хурдавчилсан тест	Туузан оношлуураар (хэмжээ, хувийн жин, PH, уураг, улаан эс, нитрит, сахар, уробилиноген, цагаан эс, кетон)	√	√	3 100
1.2		Шээсний тунадаснаас наац бэлтгэж микроскопоор шинжлэх (техникчтэй бол)	√	√	4 000
1.3	Бүрэн автомат жижиг анализатор	Өөрийн ЭМТ дээрээ шээсний бүх үзүүлэлтийг шинжилсэн	√	√	7 700
2	Цусны шинжилгээ				
2.1	Гардан үйлдлээр	Цусны бүлэг тодорхойлох	√	√	1 100
2.2		Цусны резус бүлэг үзэх	√	√	1 600
2.3	Хагас автомат анализатор	Гемоглобин тодорхойлох	√	√	2 300
2.4		Цагаан эс	√	√	800
2.5		Улаан эс	√	√	800
2.6		Ялтас эс	√	√	800
2.7		Улаан эсийн тунах хурд тодорхойлох	√	√	4 000
2.8		Гематокрит*	√	√	2 400
2.9		Цусны наац бэлтгэн Гемза эсвэл Эозин Гематотоксинаар будаж лейкоцитыг ялгаж авах	√	√	4 700
2.10		Коагулограмма	√	√	10 000
2.11	Бүрэн автомат жижиг анализатор	Өөрийн ЭМТ дээрээ цусны бүх үзүүлэлтийг шинжилсэн	√	√	9 100
3	Биохимийн шинжилгээ				
3.1	Хагас автомат анализатор	Цусанд сахар үзэх (өглөөний өлөн цусанд тодорхойлох)	√	√	4 700
3.2		Глюкозын зохих тунг өгсөнөөс хойш 1 ба 2 цагийн дараа цусны сахар тодорхойлох	√	√	2 200
3.3		Билирубин тодорхойлох	√	√	2 300
3.4		Уураг тодорхойлох	√	√	3 700

3.5		АЛАТ тодорхойлох	√	√	3 200
3.6		АСАТ тодорхойлох	√	√	4 000
3.7		Креатинин (сийвэн болон шээсэнд)	√	√	4 500
3.8		Амилаза	√	√	2 400
3.9		Шүлтлэг фосфатаза (ШФ)	√	√	2 400
3.10		Гаммаглутамилтрансфераз (ГГТ)	√	√	1 600
3.11		Холестрин	√	√	3 900
3.12		С урвалжит уураг	√	√	2 400
3.13	Бүрэн автомат жижиг анализатор	Өөрийн ЭМТ дээрээ биохимийн бүх үзүүлэлтийг шинжилсэн	√	√	17 100
4	Хурдавчилсан оношлуур				
4.1		HBV хурдавчилсан сорил	√	√	3 500
4.2		HCV хурдавчилсан сорил	√	√	
4.3		Тэмбүүгийн хурдавчилсан сорил	√	√	5 400
4.4		ХДХВ хурдавчилсан сорил	√	√	5 400
4.5		Томуугийн хурдавчилсан сорил	√	√	1 600
4.6		Суулгалтат халдварыг илрүүлэх	√	√	1 600
4.7		Хеликобактер илрүүлэх	√	√	5 700
4.8		Сахар илрүүлэх	√	√	2 600
4.9		Холестрин илрүүлэх	√	√	2 600
4.10		Тропонин хурдавчилсан оношлуур (шигдээс)	√	√	4 000
4.11		Стафилококкийн хурдавчилсан сорил	√	√	4 000
4.12		Стрептококийн хурдавчилсан сорил	√	√	4 000
4.13		Өтгөнд далд цус тодорхойлох (микроскопоор харах)	√	√	4 000
4.14		Шимэгч хорхойн өндөг илрүүлэх (микроскопоор харах)	√	√	1 600
4.15		Хавдрын маркер	√	√	7 800
5	Эмэгтэйчүүдийн сорил *				
5.1		Умайн хүзүүний эсийн шинжилгээ авах (ПАП сорил)	√	√	8 000
5.2		Үтрээний арчдасын шинжилгээ	√	√	4 700
6	Оношилгоо				
6.1		Зүрхний цахилгаан бичлэг	√	√	5 800
6.2		Хэт авиан оношилгоо	√	√	6 800
6.3		Рентген шинжилгээ	√	√	9 100

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 26 дугаар тогтоолын дөрөвдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ЗАРДЛЫН ТӨЛБӨРИЙГ ХАРИУЦАХ
ӨРХ, СУМ, ТОСГОНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВД ҮЗҮҮЛЭХ ӨДРИЙН
ЭМЧИЛГЭЭНИЙ ОНОШИЙН ХАМААРАЛТАЙ БҮЛЭГ, ӨРТГИЙН ЖИН

№	Өвчний бүлэг	Дэд дугаар	Өвчний жагсаалт	Өвчний олон улсын ангилал /ICD10/	Өртгийн жин	Сум тосгоны ЭМТ	Өрхийн ЭМТ
1	1.Зүрх судасны тогтолцооны өвчин /I00-I99/	1.1	Артерийн даралт ихсэх өвчин	I10-I15	1,147	√	√
2		1.2	Зүрхний ишеми өвчин	I20-I25		√	√
3		1.3	Зүрхний архаг, цочмог дутагдал	I24-I25		√	√
4		1.4	Хэрэх өвчин	I00-I05		√	√
5		1.5	Зүрхний гажууд /хөнгөн хэлбэр/	I05-I09, I34-I39, Q20-Q28		√	√
6		1.6	Цус багадалт /хөнгөн хэлбэр/	D50-D64		√	√
7		1.7	Тархины ишемийн инфаркт	I63		√	√
8	2.Амьсгалын тогтолцооны өвчин /J00-J99/	2.1	Гуурсан хоолойн үрэвсэл	J20-J30, J42	1,067	√	√
9		2.2	Уушгины үрэвсэлт өвчин	J12-J18, J69		√	√
10		2.3	Уушигны архаг бөглөрөлт өвчин	J44		√	√
11		2.4	Гуурсан хоолойн багтраа	J45-J46		√	√
12	3. Хоол боловсруулах тогтолцооны өвчин /K00-K99/	3.1	Амны хөндийн үрэвсэлт өвчин	K12	1,106	√	√
13		3.2	Шүд цоорох өвчин	K02		√	√
14		3.3	Залгиур хоолойн үрэвсэлт өвчин	K20		√	√
15		3.4	Ходоодны үрэвсэлт өвчин	K29		√	√
16		3.5	Гэдэсний үрэвсэлт өвчин	K52		√	√
17		3.6	Элэгний үрэвсэлт өвчин	K73		√	√
18		3.7	Элэгний хатуурал	K74		√	√
19		3.8	Нойр булчирхайн үрэвсэлт өвчин	K85-K87		√	√

20		3.9	Цэсний замын үрэвсэлт өвчин	K81-83		✓	✓
21		3.10	Ходоодны сөөргөө	K21		✓	✓
22	4.Арьсны өвчин /L00-L99/	4.11	Арьсны харшилт өвчин	L20-L30, L40-L45, L50-L59, L93-L94	1,000	✓	✓
23		4.12	Нянгийн гаралтай өвчин	L00-L02, L70,L71		✓	✓
24		4.13	Вирусын гаралтай өвчин	B02		✓	✓
25		4.14	Мөөгөнцрийн өвчин	B35-B37,B86		✓	✓
26	5.Дотоод шүүрэл ба бодисын солилцооны өвчин /E00-E99/	5.1	I Хэв шинжийн чихрийн шижин	E10	1,000	✓	✓
27		5.2	II Хэв шинжийн чихрийн шижин	E11		✓	✓
28		5.3	Бамбай булчирхайн эмгэг	E00-E07		✓	✓
29		5.4	Таргалалт	E66		✓	✓
30	6.Мэдрэлийн тогтолцооны өвчин /G00-G99/	6.1	Толгой өвдөлтийн хам шинж	G44,	0,819	✓	✓
31		6.2	Тархины цусны эргэлтийн хямрал	G45-G46		✓	✓
32		6.3	Цус харвалтын дараах тусламж, үйлчилгээ	I69		✓	✓
33		6.5	Эпилепси	G40		✓	✓
34		6.6	Тархины саажилт, нэг талын саажилт, доод мөчдийн саажилт, 4 мөчний саажилт, бусад саажилт	G81-G83		✓	✓
35		6.7	Гурвалсан мэдрэлийн өвчин	G50		✓	✓
36		6.8	Архаг ядаргаа	G24		✓	✓
37		7.Яс булчингийн тогтолцоо ба холбох эдийн өвчин /M00-M99/	7.1	Үений эмгэг, үрэвсэлт өвчнүүд		M05-14, M15-19, M20-M25	0,830
38	7.2		Ясны эмгэг, үрэвсэлт өвчнүүд		✓	✓	
39	7.3		Булчингийн үрэвсэлт өвчнүүд	M60-M63	✓	✓	
40	8.Шээс, бэлгийн тогтолцооны өвчин	8.1	Давсагны үрэвсэл	N30	1,031	✓	✓
41		8.2	Бөөрний тэвшинцрийн үрэвсэл	N10-N16		✓	✓

42	/N00-N99/	8.3	Бөөрний түүдгэнцрийн үрэвсэл	N00-N08				
43	9.Нүд ба түүний дайврын үрэвсэл /H00-H59/	9.1	Нүдний салстын хурц үрэвсэл	H10	1,000			
44		9.2	Зовхины ба дайврын үрэвслүүд	H00-H06				
45		9.3	Торлог, шилэнцрийн цус харвалт	H30-H36				
45	10.Чих, хамар, хоолойн үрэвсэл /H60-H95/	10.1	Гадна чихний үрэвсэл	H60-H62	1,000			
47		10.2	Дунд чихний үрэвсэл	H65, H66, H67				
48		10.3	Гүйлсэн булчирхайн үрэвсэл	J03				
49		10.4	Хамрын үрэвсэл	J00-J01				

---oOo---



pdfelement